

АШУУИС-ИЙН МОНГОЛ-ЯПОНЫ ЭМНЭЛГИЙН
ЕРӨНХИЙ ЗАХИРАЛ



**ХҮНСНИЙ МАТЕРИАЛ НИЙЛҮҮЛЭХ
ҮНИЙН САНАЛ
АВАХ БАРИМТ БИЧИГ**

Тендер: Хүнсний материал худалдан авах
Тендерийн дугаар: АШУУИСЭ/20200500901

Улаанбаатар хот
2020 он

Нэг. ҮНИЙН САНАЛ АВАХ УРИЛГА

АШУУИС-н Монгол-Япон эмнэлэг нь сонгогдсон эрх бүхий тендерт оролцогчдоос **Хүнсний материал** нийлүүлэх тухай үнийн санал ирүүлэхийг урьж байна.

Үнийн санал ирүүлэх барааны техникийн тодорхойлолт болон холбогдох бусад материалыг хавсаргасан болно.

Үнийн саналыг **2020 оны 08 сарын 20 өдрийн 14 цаг 00 минут-аас** өмнө **цахимаар Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар Төрийн худалдан авах ажиллагааны цахим систем www.tender.gov.mn** хаягаар ирүүлнэ.

Үнийн саналыг нээлтэд оролцох хүсэлтэй тендерт оролцогчдыг байлцуулан **2020 оны 08 сарын 20** - ны өдрийн **14 цаг 15 минутад** нээнэ.

**Монгол улс, Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг, 12-р хороо Ботаникийн гудамж.
Утас:89861422
АШУУИС-н МЯСЭ**

Хоёр. ТЕНДЕРТ ОРОЛЦОГЧДОД ӨГӨХ ЗААВАРЧИЛГАА

- | | | |
|---|------|---|
| 1. Эрх бүхий тендерт оролцогч ба эрх бүхий бараа | 1.1. | Тендерт оролцогч нь “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай” хуулийн 14-16 дугаар зүйл буюу Тендер шалгаруулалтын өгөгдлийн хүснэгт /цаашид “ТШӨХ” гэх/-д заасан холбогдох шаардлагыг хангасан байна. |
| 2. Тендер ирүүлэх, тендерийн нээлт | 2.1. | Захиалагч тендерүүдийг ТШӨХ-д заасан захиалагчийн хаягаар, ТШӨХ-д заасан огноо, цагаас өмнө хүлээн авна. |
| | 2.2. | Тендерийг ТШӨХ-д заасан хугацаанд, ТШӨХ-д заасан газар нээлтийг хийнэ. |
| | 2.3. | Тендерт оролцогч тендерийн материалд Хувь хүний нууцын тухай болон Байгууллагын нууцын тухай хуулиудаар ил болгохыг хориглосон мэдээллийг тусад нь хавтаслаж ирүүлнэ. Тус хавтасны эхэнд тэдгээр мэдээллийг нууцлах үндэслэлийг бичгээр тайлбарлаж, тендерт оролцогчийн итгэмжлэгдсэн этгээд гарын үсгээр баталгаажуулна. Эрх бүхий тендерт оролцогч болохыг нотлох ТШӨХ-д заасан баримт бичиг, тендерийн баримт бичигт заасан маягтуудыг нууцлахгүй ирүүлнэ. |
| 3. Тендерийн иж бүрдэл | 3.1. | Тендерт оролцогчийн бэлтгэж ирүүлэх тендер нь дараах зүйлээс бүрдэнэ. Үүнд:
(а) Үнийн санал;
(б) Үнийн болон нийлүүлэлтийн хуваарь;
(в) Чадварын мэдээлэл /санхүүгийн тайлан, туршлагын мэдээлэл, гэрээ гүйцэтгэсэн ажлын гэрээний хуулбар/ болон бусад баримт бичиг;
(г) Шаардлагатай бол тусгай зөвшөөрөл;
(д) [Бэлтгэж ирүүлэх шаардлагатай бусад материалыг жагсаана.] |
| 4. Тогтмол үнэ | 4.1. | Тендерт оролцогчийн санал болгосон үнэ нь төгрөгөөр илэрхийлэгдсэн байх ба гэрээг хэрэгжүүлэх хугацаанд тогтмол байна. Үнийн тохируулгын нөхцөлтэйгээр ирсэн үнийн саналаас татгалзана. |
| 5. Техникийн тодорхойлолт ба арилжааны нөхцөлүүд | 5.1. | Нийлүүлэх бараа нь техникийн тодорхойлолтын шаардлагыг бүрэн хангасныг тендерт оролцогч батлах үүрэгтэй. Нийлүүлэх бараа нь техникийн тодорхойлолтын шаардлагаас зөрсөн тохиолдолд тухайн тендерээс татгалзана. |
| | 5.2. | Тендерт оролцогч нь энэ баримт бичигт заасан арилжааны нөхцөлүүдийг бүрэн хангасныг албан бичгээр батлан тендерийн хамт ирүүлнэ. |
| 6. Үнийн саналын хүчинтэй байх хугацаа | 6.1. | Үнийн санал нь түүнийг ирүүлсэн өдрөөс хойш 5 хоногийн хугацаанд хүчинтэй байна. |

- 7. Санал болгосон үнэ, түүнийг үнэлэх**
- 7.1. Тендерт оролцогч үнийн саналдаа холбогдох бүх даатгал, тээврийн зардал, татвар, хураамжийг оруулж үнийн хуваарийн дагуу ирүүлнэ.
- 7.2. Бараа нийлүүлэлтийн хуваарьт заасан бараа нь **ТШӨХ-д** заасан багцаас бүрдэх ба багцад орсон нэр төрөл бүрд заавал үнийн санал ирүүлнэ.
- 7.3. Захиалагч техникийн тодорхойлолт болон бусад нөхцөл шаардлагыг хангасан оролцогчдын үнийг харьцуулж хамгийн бага үнэ санал болгосон тендерт оролцогчид гэрээ байгуулах эрхийг олгоно.
- 8. Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл**
- 8.1. Захиалагч нь шалгарсан тендерт оролцогчид гэрээ байгуулах эрх олгосныг түүний тендер хүчинтэй байх хугацаа дуусахаас өмнө албан бичгээр мэдэгдэнэ. Энэ мэдэгдэлд гэрээнд заасны дагуу хийгдэх ажилд төлөх мөнгөн дүн буюу гэрээний үнийг заана. Гэрээний үнэ нь залруулга болон үнийн хөнгөлөлтийг (түүний дотор нөхцөлтэй үнийн хөнгөлөлт) тооцсон тендерийн үнэ байна.

Гурав.ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН ӨГӨГДЛИЙН ХҮСНЭГТ

ТӨӨЗ-ны холбогдох заалт	А. Ерөнхий зүйл
ТӨӨЗ 1.1 ТӨӨЗ 1.1	Захиалагч нь: АШУҮИС-н Монгол-Японы эмнэлэг Тендер шалгаруулалтын нэр болон ялгагдах дугаар: Хүнсний материал худалдан авах №АШУҮИСЭ/202005009
ТӨӨЗ 1.2	Энэхүү тендер шалгаруулалт нь дараах нэр, дугаар бүхий багцуудаас бүрдэнэ: 1-р багц: Хуурай бүтээгдэхүүн ба бусад – 15,701,900 төг 2-р багц: Цагаан идээ – 8,031,000 төг 3-р багц: Мах, махан бүтээгдэхүүн – 92,739,000төг 4-р багц: Хүнсний ногоо – 26,031,000 төг 5-р багц: Гурил, будаа – 17,885,100 төг 6-р багц: Жимс – 2,052,000төг
ТӨӨЗ 2.1	Санхүүжилтийн эх үүсвэр нь: /Улсын төсөв/ Нийт төсөвт өртөг: 162,440,000 төгрөг бөгөөд энэхүү үнийн дүнгээс төрийн байгууллагын үйл ажиллагааг хэвийн, тасралтгүй явуулах үүднээс зайлшгүй шаардлагаар худалдан авсан барааны өртгийг хасаж тооцно.
	Б. Тендерийн баримт бичиг
ТӨӨЗ 8.1	Захиалагчаас тендерийн баримт бичигтэй холбоотой тодруулга авах хаяг: 89861422
ТӨӨЗ 8.1	Тендерийн баримт бичгийн талаар тодруулга авах хүсэлтийг хүлээн авах хугацааны хязгаар тендер хүлээн авах эцсийн хугацаанаас ажлын 2 хоногоос багагүй байна.
	В. Тендер бэлтгэх
ТӨӨЗ 11.1	Хэрэв тендерт гадаадын этгээд оролцох эрхтэй бол тендерийн хэл нь Монгол хэл дээр байна.
ТӨӨЗ 12.1 (ё)	Тендерт оролцогч дараах нэмэлт материалыг өөрийн тендерт хавсралтаар ирүүлнэ.Үүнд: 1. Улсын бүртгэлийн гэрчилгээний эх хувиас хийсэн хуулбар нотариатаар баталгаажсан. 2. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газраас өр төлбөргүйг тодорхойлсон тодорхойлолт ирүүлэх /эх хувь байх/, тендер зарласнаас тендер хүлээн авах хугацаагаар байна. 3. Үндэсний татварын албаны цахим тодорхойлолт 4. Гэрээний ерөнхий, тусгай нөхцөл болон нэмэлт нөхцөлийг хүлээн зөвшөөрч байгаа тухай албан мэдэгдэл 5. Тендерийн маягт бөглөж ирүүлэх /Маягт №ТШМ-1/ 6. Бараа нийлүүлэлтийн хуваарь болон барааны үнийн хуваарийг гарган ирүүлнэ 7. Тендерт оролцогчийг төлөөлж тендерт гарын үсэг зурах этгээдийн гарын үсгийг баталгаажуулж гаргасан итгэмжлэл
ТӨӨЗ 14.1	Хувилбарт тендер ирүүлэхийг “зөвшөөрөхгүй
ТӨӨЗ 15.5	Олон улсын худалдааны Incoterms/Инкотермс -ийн хувилбар: : “Incoterms 2000”

ТӨӨЗ 15.9	Бараа хүргэгдэх газар: Монгол улс, Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг 12-р хороо Ботаникийн гудамж АШУУИС-н Монгол-Япон сургалтын эмнэлэг
ТӨӨЗ 15.9 (б) (1)	Монгол Улсын хилээс гадна үйлдвэрлэгдэх барааг нийлүүлэх үнэ нь ТӨӨЗ-ны 15.9.(б).(1) дэх хэсэгт заасан СІР үнэ байна.
	Тендерт оролцогчийн санал болгосон тендерийн үнэд тухайн бараа, материалыг захиалагчийн бараа хүргэгдэх эцсийн цэгт хүргэхэд гарах бүхий л зардал болон татвар, төлбөр, хураалж орсон байна.
ТӨӨЗ 15.10	Тендерт оролцогчийн санал болгосон үнийг гэрээний хэрэгжилтийн явцад тохируулахгүй тогтмол байна.
ТӨӨЗ 16.1	Тендерийн валют: “Төгрөг” байна
ТӨӨЗ 18.1 (а)	Үйлдвэрлэгчийн зөвшөөрөл: “шаардлагатай”
ТӨӨЗ 18.1 (б)	Санхүүгийн тайлан ирүүлэх жилийн тоо: 1 жил, 2019 он
ТӨӨЗ 18.1 (г)	Ижил төстэй ажил гэрээгээр гүйцэтгэсэн туршлагын мэдээлэл ирүүлэх жилийн тоо: 1жил /2019 он/
ТӨӨЗ 18.1 (д)	Барааг нийлүүлсний дараах засвар, үйлчилгээ: Шаардлагатай. 1. Техникийн тодорхойлолтын дагуу шаардлага хангаагүй хүнсний бүтээгдэхүүнийг шинэ, шаардлага хангасан хүнсний бүтээгдэхүүнээр солих үүрэг хүлээх тухай тодорхойлолт ирүүлнэ. 2. Хүнсний бүтээгдэхүүнийг бараа нийлүүлэлтийн хуваарийн дагуу нийлүүлэх бүрт тухайн барааны эрүүл ахуйн шаардлага хангасан бичиг ирүүлэх.
ТӨӨЗ 18.2	Борлуулалтын хэмжээ: Тендерт ирүүлсэн санхүүгийн тайлангийн 1
ТӨӨЗ 18.4	Дотоодын давуу эрхийн зөрүү: “тооцохгүй”
ТӨӨЗ 20.1	Тендер нээснээс хойш 30 хоногийн туршид хүчинтэй байна
ТӨӨЗ 21.1	Тендерийн баталгааны үнийн дүн: Шаардлагатай. 1-р багц: Хуурай бүтээгдэхүүн ба бусад – 157,019 төг 2-р багц: Цагаан идээ – 80,310 төг 3-р багц: Мах, махан бүтээгдэхүүн – 927,390төг 4-р багц: Хүнсний ногоо – 260,310 төг 5-р багц: Гурил, будаа – 178,851 төг 6-р багц: Жимс – 20,520 төг
ТӨӨЗ 22.2	Тендерийн эх хувиас гадна ирүүлэх хуулбар хувийн тоо: [шаардлагагүй]
	Г. Тендер ирүүлэх
ТӨӨЗ 23.3 (б)	Тендер хүлээн авах захиалагчийн хаяг: Тендерт оролцогч нь цахим худалдан авах ажиллагааны систем /www.tender.gov.mn/-д өөрийн аж ахуйн нэгжийн хувийн нууцлалын кодоор нэвтрэн орж тендерийн материалаа цахим /PDF/ хэлбэрээр ирүүлнэ. Байгууллагын хаяг: Монгол улс, Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг 12-р хороо Ботаникийн гудамж АШУУИС-н Монгол-Японы эмнэлэг Тендерийн нээлтийг цахим худалдан авах ажиллагааны системээр нээнэ. Давхар болон өрөөний дугаар: МЯЭмнэлгийн 3 давхарын хурлын танхим Аймаг, хот: Улаанбаатар хот Баянзүрх дүүрэг. Шуудангийн дугаар: Улс: “Монгол Улс”

<p>ТӨӨЗ 23.3 (в)</p>	<p>Тендер шалгаруулалтыг ялгаж, таних зорилгоор тендерийн гаднах болон доторх дугтуйд дараах нэр, ялгах дугаарыг гаргацтай тэмдэглэнэ: : <i>Хүнсний материал худалдан авах №АШУУИСЭ/202005009/01</i></p>
<p>ТӨӨЗ 24.1 ТӨӨЗ 24.1</p>	<p>Тендер хүлээн авах эцсийн хугацаа нь: Огноо: 2020 оны 08 дугаар сарын 20 ны өдөр</p> <p>Цаг: 14 цаг 00 минут</p> <p>Тендер хүлээн авах эцсийн хугацаа нь цахим системийн цагаар тооцогдох бөгөөд хугацаа хоцорсон тендерийг хүлээн авах боломжгүй. Тендерт оролцогч нь тендер хүлээн авах эцсийн хугацаа дуусахаас өмнө илгээсэн тендерийн материалаа засварлах, нэмэлт өөрчлөлт оруулах эрхтэй.</p>
<p>Д. Тендерийг нээх, үнэлэх</p>	
<p>ТӨӨЗ 28.1 ТӨӨЗ 28.1</p>	<p>Тендерийн нээлт хийх газрын хаяг нь дор өгөгдөв. Үүнд: Байгууллагын хаяг: <i>Монгол улс, Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг 12-р хороо Ботаникийн гудамж АШУУИС-н Монгол-Японы эмнэлэг</i> Давхар болон өрөөний дугаар: <i>Тендерийн нээлтийг цахим худалдан авах ажиллагааны системээр нээх бөгөөд Монгол Японы Эмнэлгийн 3 давхарын хурлын танхимд нээнэ.</i></p> <p>Аймаг, хот: <i>Улаанбаатар хот Баянзүрх дүүрэг.</i> Шуудангийн дугаар: үгүй Улс: “Монгол Улс” Тендерийн нээлт хийх огноо, цаг нь: Огноо: 2020 оны 08 дугаар сарын 20-ны өдөр Цаг: 14 цаг 15 минут</p>
<p>Е. Гэрээ байгуулах эрх олгох</p>	
<p>ТӨӨЗ 40.1</p>	<p>Захиалагч барааны тоо хэмжээг бууруулж болох хамгийн их хувь: [15%] Нийлүүлэх барааны тоо хэмжээг өсгөж болох хамгийн их хувь: [20%]</p>

Гурав. ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ

Багц-1. Хуурай бүтээгдэхүүн бусад						Ерөнхий шаардлага
Д/д	Бараа материалын нэр, төрөл	Савалгаа /хэмжээ/	Хэмжих нэгж	Тоо ширхэг	Шаардлага	
1	Давс	1 кг	ширхэг	80		Үйлдвэрлэсэн огноо болон хаяжилт нь Монгол тайлбартай. Шинжилгээний бичгийн хамт
2	Дүпү	250 гр	ширхэг	60		
3	Мөөг	250 гр	ширхэг	8	Шилтэй	
4	Самар	150 гр	ширхэг	10	лаазтай, давсалсан	
5	Хар перец	40 гр	ширхэг	98	Нунтаг	
6	Дошида	1 кг	ширхэг	50		
7	Роллтон	100 гр	ширхэг	48		
8	Курицы	40 гр	ширхэг	30		
9	Кужужан		ширхэг	2		
10	Канжан цуу	14 л	ширхэг	12		
11	Карри	1 кг	ширхэг	3		
12	Томат	3 кг	ширхэг	24	Лаазтай	
13	Hunts соус	500 гр	ширхэг	48		
14	Чихэрлэг соус	700 гр	ширхэг	25		
15	Отто	3.3 кг	ширхэг	6	Лаазтай	
16	Тириаки соус	500 гр	ширхэг	34		
17	Арвайтай цай	30 ширхэгтэй	хайрцаг	24		
18	Бакеттай цай		ширхэг	20	Хөвсгөл цайтай дүйцэхүйц	
19	Ургамлын тос	1 л	ширхэг	550	олейна оливтой дүйцэхүйц, шаталт бага, үнэргүй	
20	Гүнжидийн тос	300гр	ширхэг	24		
21	Гүнжидийн үр		кг	2		
22	Оливийн тос	1л	ширхэг	1		
23	Дрожжи	500гр	ширхэг	24		
24	Шингэн утаа	500гр	ширхэг	4		
25	Алимны цуу	1.5 л	ширхэг	3		
	Уксус	200 мл	ширхэг	4		
26	Нунтаг сармис	40гр	ширхэг	10		
27	Орегано	40 гр	ширхэг	25		
28	Желатин	25гр	ширхэг	50		
29	Бялууны хөөлгөгч	10гр	ширхэг	25		
31	Ваниль	10гр	ширхэг	20		
32	Хүнсний будаг	140 гр	ширхэг	3		
33	Тортны үрэл	120 гр	ширхэг	2	Өнгөний сонголттой	
34	Кексний аяга	100 ширхэг	Боодол	10	Өнгөний сонголттой	
35	Хүнсний сод	400 гр	ширхэг	20		
36	Сыр		кг	20	Хуудсан	
37	Хар олив	500 гр	ширхэг	3		

38	Бүхэл үрийн печень	900 гр	ширхэг	12	
39	Кокос		кг	2	
40	Таты крем	1 кг	ширхэг	12	
41	Шоколад 80%	2 кг	ширхэг	4	Хольцгүй хар
42	Гич	340 гр	ширхэг	25	
43	Зөгийн бал	500 гр	ширхэг	20	
45	Цагаан дарс	1 л	ширхэг	2	Чихэрлэг
46	Улаан дарс	2 л	ширхэг	5	Чихэрлэг
47	Өндөг		ширхэг	10,000	Дундаж хэмжээтэй /цагаан/
48	Түрс	110 гр	ширхэг	3	Улаан, хар
49	Бор мөөг		кг	60	
50	Майонез	3 л	ширхэг	35	Өтгөн
51	Будаа амтлагч	300 гр	ширхэг	100	
52	Кунамули		кг	15	
53	Үдэн	300 гр	ширхэг	45	
54	Кимчи		кг	34	
55	Догг	500 гр	ширхэг	20	
56	Миог	250 гр	ширхэг	20	
57	Тортила гурил	/18 см/	ширхэг	30	
58	Ананас	850 гр	ширхэг	20	лаазтай, жижиглэн хэрчсэн
59	Крахмал	300 гр	ширхэг	20	
60	Жан	1 л	ширхэг	3	
61	Бургер талх	5 ширхэгтэй	ширхэг	60	
62	Сухар	1 кг	ширхэг	20	
	Варень	500гр	ширхэг	168	
63	Компот	500 гр	ширхэг	8	лаазтай, тоор жимстэй
64	Сэндвич талх		ширхэг	50	
Цагаан идээ					
Д/д	Бараа материалын нэр, төрөл	Савалгаа /хэмжээ/	Хэмжих нэгж	Тоо ширхэг	Шаардлага
1	Сүү	1 л	ширхэг	1,680	
2	Цөцгийтэй тараг	1 л	ширхэг	40	
3	Эзгий		кг	15	
4	Шар тос		кг	3	
5	Зөөхий		кг	60	
6	Бяслаг		кг	20	
7	Масло		кг	350	Орос
8	Аарц		кг	100	Исгэлэн биш
Мах махан бүтээгдэхүүн					
Д/д	Бараа материалын нэр, төрөл	Савалгаа /хэмжээ/	Хэмжих нэгж	Тоо ширхэг	Шаардлага
1	Булууны яс		кг	550	
2	Зайдас		кг	25	

3	Хиам		кг	50	Хагас утлагатай
4	Мах-хонь		кг	2500	гуяа цул
5	Мах-хонь таташ		кг	2,200	гуяа цул-таташ
6	Татсан гэдэс		кг	100	
	Таван цул		Кг	20	
8	Мах цагаан загас		кг	40	
9	Мах-тахиа-цул		кг	600	
12	Хонины сүүл		кг	20	
13	Үхрийн гүзээ		кг	25	
14	Элэг		кг	60	Үхрийн элэг
15	Туна	0.2гр	ширхэг	25	
16	Бекон мах-250гр	250 гр	ширхэг	25	
17	Гахайн мах		кг	60	
18	Үхрийн тойг		кг	360	
19	Мах- үхэр гуя-цул		кг	1,300	
20	Мах-үхэр гуя-таташ		кг	1,000	
21	Мах -тахиа-мөч		кг	30	
22	Мах- тахиа- цээж		кг	24	
23	Хонины хавирга		кг	40	
Хүнсний ногоо					
Д/д	Бараа материалын нэр, төрөл	Савалгаа /хэмжээ/	Хэмжих нэгж	Тоо ширхэг	Шаардлага
1	Төмс		кг	2,500	
2	Лууван		кг	1,200	
3	Манжин		кг	400	
4	Хүрэн манжин		кг	350	
5	Байцаа		кг	2,400	
6	Хүрэн байцаа		кг	200	
7	Цоо байцаа		кг	100	
8	Сонгино		кг	840	
9	Ногоон сонгино		кг	120	
10	Сармис		кг	10	
11	Чинжүү		кг	600	
12	Цэцэгт байцаа		кг	350	
13	Броколи		кг	350	
14	Шар хулуу		кг	240	
15	Ногоон хулуу		кг	480	
16	Хаш		кг	50	
17	Сармисны гол		боодол	30	
18	Юуцай		кг	240	
19	Бууцай		кг	240	
20	Яншуй		кг	5	
21	Шанцай		кг	20	
22	Хүрэн салат навч		кг	10	
23	Салат навч		кг	160	
24	Өргөст хэмх		кг	400	
25	Том помидор		кг	24	
26	Үрлэн помидор		кг	80	
27	Вандуй	250 гр	ширхэг	30	лаазтай
28	Даршилсан огурцы	3 л	ширхэг	30	

29	Эрдэнэшиш	лаазтай	ширхэг	40			
30	Цагаан гаа		кг	5			
32	Редиска		кг	10			
33	Хүрэн шош	425 гр	ширхэг	50	лаазтай		
34	Вандуй хавтгай		кг	10			
Гурил , будаа							
Д/д	Бараа материалын нэр, төрөл	Савалгаа /хэмжээ/	Хэмжих нэгж	Тоо ширхэг	Шаардлага		
1	Гурил-Дээд гурил	25 кг	ширхэг	140	Алтан тариан дээд гурилтай дүйцэхүйц	Хэт жижиг биш, хорогдол багатай, Монгол ногоо. Шинжилгээний бичгийн хамт	
2	Гурил -бүхэл үр	5кг	ширхэг	90			
3	Гурил 2-р зэрэг	1кг	ширхэг	300			
5	Цагаан будаа	25 кг	ширхэг	130	Япон будаатай дүйцэхүйц		
6	Будаа гурвалжин	1 кг	ширхэг	160			
7	Хөц будаа	1 кг	ширхэг	144			
8	Шар будаа	1 кг	ширхэг	96			
9	Хар будаа		кг	2			
10	Элсэн чихэр	50 кг	ширхэг	5			
13	Хүнсний хивэг	0.4 кг	ширхэг	60			
14	Хүүхдийн будаа	1 кг	ширхэг	144			
15	Овьёос		ширхэг	180	Алейкатай дүйцэхүйц		
16	Арвайн гурил	1 кг	ширхэг	20			
17	Гоймон-туузан	3 кг	ширхэг	20	Лапшатай дүйцэхүйц		
18	Гоймон- эрвээхэй	1 кг	ширхэг	120			
19	Мушгиа	5 кг	ширхэг	10			
20	Бор гоймон-жижиг	1 кг	ширхэг	30			
21	Пүнтүүз		ширхэг	20			
22	Шпагети гоймон	800 гр	ширхэг	100			
Жимс							
Д/д	Бараа материалын нэр, төрөл	Савалгаа /хэмжээ/	Хэмжих нэгж	Тоо ширхэг	Шаардлага		
1	Нэрс	20 л	ширхэг	1	Өтгөн исгэлэн биш		Үйлдвэрлэсэн огноо болон хаяжилт нь Монгол тайлбартай.Хэт жижиг биш, хорогдол багатай. Шинжилгээний бичгийн хамт
2	Чацаргана	20 л	ширхэг	1	Өтгөн исгэлэн биш		
3	Лийр		кг	15			
5	Алим		кг	40			
6	Жүрж		кг	10			
7	Киви		кг	20			
8	Банана		кг	10			
9	Усан үзэм		кг	10			

10	Аньсны шүүс	20 л	ширхэг	1	Өтгөн исгэлэн биш
11	Ногоон алим		кг	30	
12	Лемон		кг	8	
13	Үзэм	13 кг	хайрцаг	6	
14					

- 1. Стандарт:** Монгол улсад хүчин төгөлдөр үйлчилж буй стандартад нийцсэн, тухайн барааны гарал үүслийн улсын зохих шаардлагыг хангасан байна. Үүнд: эдгээр стандартын хамгийн сүүлийн найруулгыг ойлгоно. Стандартад нийцэхгүй бараа бүтээгдэхүүн нийлүүлсэн бол тухай бараа, бүтээгдэхүүнийг хорогдолд тооцно.
- 2. Баглаа, боодол:** Улаанбаатар хот дахь захиалагчийн агуулахад нийлүүлэх шаардлагыг хангасан байх бөгөөд өмнө нь ашиглаж байгаагүй шинэ, капитал засвар хийгээгүй байх шаардлагатай, нийлүүлэгчийн итгэмжлэгдсэн төлөөлөгч өөрийн биеэр хүлээлгэн өгч акт үйлдэнэ.
- 3. Бараа хүргэх газар:** *Монгол улс, Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг, 12-р хороо Ботаникийн гудамж. АШУҮИС-ийн Монгол-Японы эмнэлэг*

Дөрөв. **ЖИШИГ МАЯГТ**

1. ҮНИЙН САНАЛЫН МАЯГТ

[огноо]

(Захиалагч байгууллагын нэр)-ын дарга _____ танаа

1. Бид, [тендерт оролцогчийн нэр] дор дурдсан барааг [санал болгож буй нийт үнийг тоогоор болон үсгээр] төгрөгөөр үнийн саналын авах баримт бичгийн дагуу [тоо] хоногийн дотор нийлүүлэхээр санал болгож байна.
2. Нийлүүлэх бараа нь техникийн тодорхойлолтын шаардлагыг бүрэн хангасныг гэрчлэх баримтыг хавсаргав.
3. Бид гэрээний ерөнхий болон тусгай нөхцөлийг хүлээн зөвшөөрч байна гэдгийг үүгээр батламжилж байна.

Нэр төрөл	Тодорхойлолт	Барааны гарал үүслийн улс	Тоо ширхэг	Нэгж үнэ	Нийт дүн	НӨАТ болон бусад албан татвар	Бүгд дүн
1	2	3	4	5	6	7	8
Тендерийн нийт үнэ							

4. Бид тендерийг холбогдох журмын дагуу бусад тендерт оролцогчдод ил болгохыг үүгээр зөвшөөрч байна. Захиалагч бидний ирүүлсэн тендерийг нууцлах аливаа үүргээс бүрэн чөлөөлөгдөнө.

Баталгаат засварын хугацаа:

Санал болгож буй бусад нөхцөл:

Тендерт оролцогчийн нэр:

Эрх бүхий албан тушаалтны гарын үсэг, тамга:

Албан тушаал, нэр:

Хаяг:

2. НЭГДСЭН ХҮСНЭГТ: ӨМНӨ БОЛОН ОДОО ХЭРЭГЖИЖ БҮЙ ГЭРЭЭ

Тендерт оролцогч хэрэгжүүлсэн болон одоо гүйцэтгэж буй бүх гэрээний талаар мэдээлэл ирүүлнэ.

Уг мэдээлэл нь гэрээ хэрэгжүүлэх чадавхигүй болсон эсхүл ажил дуусгавар болсон гэрчилгээ буюу ажил хүлээлцсэн актаа хүлээн авч байгаа гэрээний хувьд хамаарахгүй.

Гэрээний нэр	Захиалагч, холбоо барих хаяг/утас/факс	Гэрээний үнийн дүн	Гэрээний эхлэх хугацаа	Гэрээний дуусах хугацаа
1.				
2.				
3.				
4.				
5.				
бусад.				

Тав. ГЭРЭЭНИЙ ЕРӨНХИЙ НӨХЦӨЛ

- | | |
|--|---|
| 1. Шалгах болон турших | 1.1. Техникийн тодорхойлолтыг хангаж буй эсэхийг баталгаажуулах зорилгоор захиалагч эсхүл түүний төлөөлөгч барааг шалгах, турших эрхтэй. Гэрээний тусгай нөхцөл (ГТН)-д, эсхүл техникийн тодорхойлолтод захиалагч ямар шалгалт, туршилтыг хэзээ, хаана хийхийг заана. |
| 2. Барааны нийлүүлэлт ба баримт бичгийн бүрдүүлэлт | 2.1. Нийлүүлэгдэх бараа нь техникийн тодорхойлолтод нийцсэн байх ба холбогдох стандартыг заагаагүй бол тухайн барааны гарал үүслийн улсын зохих стандартад нийцсэн байна. Үүнд эдгээр стандартын хамгийн сүүлчийн найруулгыг ойлгоно. Нийлүүлэгч ГТН-д заасан бол түүний дагуу тээврийн болон бусад баримт бичгийг бэлтгэж бүрдүүлнэ. |
| 3. Оюуны өмчийн эрх | 3.1. Бараа, эсхүл түүний эд ангийг өмчлөх, ашиглахад патент, худалдааны тэмдэг, зураг төслийн эрх гэх мэт оюуны өмчийн эрхийг захиалагч болон нийлүүлэгч зөрчсөн хэмээн гуравдагч этгээдийн нэхэмжилсэн гомдлыг нийлүүлэгч барагдуулж, холбогдон гарах зардлыг хариуцна. |
| 4. Бараа хүргэх, тээврийн баримт бичиг ирүүлэх | 4.1. Гэрээнд хэрэглэсэн үнэ болон бусад худалдааны нэр томъёог Инкотермс (INCOTERMS) буюу Парис хот дахь Олон улсын худалдааны танхимаас боловсруулж гаргасан сүүлийн хувилбарт тодорхойлсон утгаар ойлгоно. |
| 5. Баталгаат засварын хугацаа | 5.1. Үйлдвэрлэгчийн тухайн бараанд олгодог баталгаат засварын хугацаа 1 жил байна. |
| 6. Гэрээнд өөрчлөлт оруулах | 6.1. Гэрээний дагуу нийлүүлэгдэх барааны нэр төрөл, үзүүлэлтийг өөрчлөхгүй. |
| 7. Төлбөр | 7.1. Захиалагч төлбөрийг нэхэмжлэх хүлээн авснаас хойш [ГТН-д заасан тоо] хоногийн дотор шуурхай хийнэ. |
| 8. Бараа нийлүүлэх хуваарь | 8.1. Нийлүүлэгч барааг хүргэхдээ техникийн тодорхойлолтод заасан бараа нийлүүлэлтийн хуваарийг мөрдөнө. |
| 9. Алданги оногдуулах | 9.1. Захиалагч нийлүүлэгчийн хугацаа хоцорч нийлүүлсэн бараа, гүйцэтгэсэн үйлчилгээний гэрээний үнийн ГТН-д заасан хувьтай тэнцэх алданги оногдуулж, гэрээний үнийг тэр хэмжээгээр бууруулна. Алдангийн нийт дүн ГТН-д заасан дээд хэмжээнээс хэтрэхгүй. |
| 10. Үүргээ биелүүлээгүй-гээс гэрээг цуцлах | 10.1. Нийлүүлэгч гэрээний үүргээ биелүүлээгүй тохиолдолд захиалагч гэрээг цуцалж, захиалагчид учирсан аливаа хохирлыг нийлүүлэгч барагдуулна. |
| 11. Маргааныг шийдвэрлэх | 11.1. Талууд гэрээний үүргийн биелэлттэй холбогдсон асуудлаар тохиролцоонд хүрч чадахгүй бол зохих тал шүүхэд нэхэмжлэл гаргана. |

Зургаа. ГЭРЭЭНИЙ ТУСГАЙ НӨХЦӨЛ

1. Шалгах болон турших (ГЕН – 1) 1.1. [Гэрээний ерөнхий нөхцөлийн 1 дүгээр зүйлийг дэлгэрүүлэх шаардлагатай бол ямар шалгалт болон туршилтыг хэн, хэзээ хийх нөхцөлийг заана.]
2. Барааны нийлүүлэлт ба баримт бичгийн бүрдүүлэлт (ГЕН – 2) 2.1. Нийлүүлэгчийн бүрдүүлэх тээврийн болон бусад баримт бичгүүд:
- 1) нийлүүлэгчийн барааны нэр, тоо ширхэг, нэгж болон нийт үнийг заасан нэхэмжлэхийн хувь;
 - 2) барааг хүргэсэн тухай баримт, төмөр замын болон тээврийн баримт;
 - 3) үйлдвэрлэгчийн буюу нийлүүлэгчийн баталгаат засварын гэрчилгээ;
 - 4) үйлдвэрийн буюу эрх бүхий байгууллагын шалгалтын гэрчилгээ;
 - 5) барааны гарал үүслийн гэрчилгээ.
- Энд жагсаасан баримт бичгийг бараа хүрэлцэн ирэхээс өмнө захиалагчид өгсөн байна. Баримт бичгийг энэ хугацаанд захиалагчид өгч чадаагүйгээс гарах зардлыг нийлүүлэгч хариуцна.
3. Баталгаат засвар (ГЕН-5) 5.1. Баталгаат засварын тусгай шаардлага.
- [Гэрээний ерөнхий нөхцөлийн 5 дугаар зүйл нь баталгаат засварын тухай нийтлэг заалтыг агуулна. Энэхүү нийтлэг заалтыг өөрчлөх шаардлага гарвал энд тусгана.]
4. Төлбөр (ГЕН – 7) 7.1. Гэрээний ерөнхий нөхцөлийн 7 дугаар зүйлийг дараах байдлаар дэлгэрүүлнэ. Үүнд:
- Гэрээний үнийн дүнгийн **[100]¹** хувийг барааг хүлээн авсан акт болон гэрээний ерөнхий нөхцөлийн 2 дугаар зүйлд заасан баримт бичгийг үндэслэн төлнө.
5. Алданги оногдуулах (ГЕН - 9)² 9.1. Алданги оногдуулах хувь: **[0,1]**
- Алдангийн нийт дүн: **[10%-иас ихгүй байна]**

¹Ихэнхтохиолдолд 100 хувь байна. Шаардлагатай бол төлбөрийн хуваарийг өөрчилнө.

² Ихэнх тохиолдолд, нэг долоо хоногт оногдуулах алданги гэрээний үнийн 0.5 хувиас, алдангийн нийт дүнгэрээ нийүүнийн дүнгийн 10 хувиас тус тус хэтрэхгүй.

Долоо. ГЭРЭЭНИЙ МАЯГТ³

БАТЛАВ.

ЗАХИАЛАГЧ
“АШУҮИС-н Монгол-Япон сургалтын
эмнэлэг

(Тамга, тэмдэг)

(Гарын үсэг)

(Албан тушаал)

НИЙЛҮҮЛЭГЧ

(Тамга, тэмдэг)

(Гарын үсэг)

(Албан тушаал)

[Тендер шалгаруулалт/гэрээний нэр] гэрээ.

Дугаар № [Тендер шалгаруулалт/гэрээний дугаар]

..... хот/аймаг

Нэг талаас **[захиалагчийн нэр]** (цаашид “захиалагч” гэх), нөгөө талаас **[нийлүүлэгчийн нэр]** (цаашид “нийлүүлэгч” гэх) дараах зүйлийг харилцан тохиролцож _____ оны __ сарын ____ -ны өдөр энэхүү ГЭРЭЭГ (цаашид “гэрээ” гэх) байгуулав.

1. Монгол Улсын Иргэний болон бусад хууль тогтоомжийн дагуу бараа, бүтээгдэхүүн нийлүүлэхтэй холбогдон захиалагч, нийлүүлэгчийн хооронд үүсэх харилцааг зохицуулах, харилцан хүлээх үүрэг, хариуцлагыг тогтооход энэхүү гэрээний ач холбогдол оршино.
2. Захиалагч нь **[гэрээний нэр, дугаар]**-г (цаашид “бараа” гэх) **[гэрээний үнийг тоогоор болон үсгээр]** (цаашид “гэрээний үнэ” гэх) нийлүүлэхээр ирүүлсэн нийлүүлэгчийн тендерийг үүгээр хүлээн зөвшөөрөв. Гэрээний үнэ нь санхүүжилтийн нийт гүйцэтгэл болно.
3. Захиалагч нь барааны нийлүүлэлтийг _____ төгрөгийн улсын төсвийн хөрөнгөөр, _____ төгрөгийн орон нутгийн төсвийн хөрөнгөөр, _____ төгрөгийн өөрийн хөрөнгөөр санхүүжүүлнэ.
4. Нийлүүлэгч нь _____ нэр төрлийн барааг _____ оны __ дугаар сарын ____ -наас _____ оны __ дугаар сарын ____ -ны өдрийн дотор нийлүүлж хүлээлгэж өгнө.
5. Дор дурдсан баримт бичиг нь гэрээний салшгүй хэсэг болно (цаашид “гэрээний баримт бичиг” гэх). Үүнд:

Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл;
Бусад шаардлагатай баримт бичиг⁴;
Үнийн санал;
Гэрээний тусгай нөхцөл;
Гэрээний ерөнхий нөхцөл;
Техникийн тодорхойлолт болон бараа нийлүүлэлтийн хуваарь;
Санхүүжилтийн хуваарь.

³ Гэрээбайгуулахүедүүнийгхасна.

⁴ Хоёрталхарилцантохиролцожгэрээнийнөхцөлдоруулсанзайлшгүйшаардлагатайнэмэлт, өөрчлөлтүүд.

Гэрээ нь энд дурдсан барааны нийлүүлэлтийн талаарх талуудын хоорондын эцсийн тохиролцоо болох ба урьд өмнө үйлдсэн бүх хэлцлийг орлоно. Хэрэв гэрээний баримт бичгүүд хоорондоо зөрчилдвөл дээр дурдсан дарааллын дагуу ач холбогдол өгч шийдвэрлэнэ.

6. Нийлүүлэгч нь энэ гэрээний дагуу захиалагчийн төлөх төлбөрийг үндэслэн энэхүү гэрээний бүх нөхцөл, болзолд нийцүүлэн энд заасан барааг нийлүүлж, гэмтэл согог арилгах үүрэг хүлээнэ.
7. Захиалагч нь гэрээний дагуу нийлүүлэгчийн нийлүүлэх бараа болон гэмтэл согог арилгах үйлчилгээг үндэслэн гэрээний үнэ, эсхүл тухайн үед гэрээний заалтын дагуу төлөх бусад дүнг гэрээнд заасан хэлбэрээр нийлүүлэгчид төлөх үүрэг, хүлээнэ.
8. Гэрээнд холбогдох асуудлаар талууд албан бичгээр буюу шуудан, телекс, цахилгаан болон факсаар харилцана.

ЗАХИАЛАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

[Албан тушаал, нэр]
*[Гарын үсэг]*_____

ТАМГА

[Захиалагчийн хаяг]
[Утас/факсын дугаар]
[Харилцагч банкны нэр, дансны дугаар]

НИЙЛҮҮЛЭГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

[Албан тушаал, нэр]
*[Гарын үсэг]*_____

ТАМГА

[Захиалагчийн хаяг]
[Утас/факсын дугаар]
[Харилцагч банкны нэр, дансны дугаар]